

**Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтсийн салбар  
хариуцсан мэргэжилтэн Шакизагийн Манзелханы  
ажил байдлын тодорхойлолт**

Ш.Манзелхан нь 1964 онд төрсөн. Эмэгтэй.50 настай ам бүл 5.Ерөнхий боловсролын сургуулийг 1982 онд төгсөж, Улаанбаатар хотод Санхүү Эдийн Засгийн техникумын Статистикийн ангид элсэн орж 1984 онд тус сургуулийг төгсөж Баян-Өлгий аймгийн АДХГЗ-ны Статистикийн хэлтсийн захиалгаар Статистикч-Операторч хос мэргэжилээр төгссөн, 2006 онд Завхан аймаг дахь МУИС-ийн салбар сургуулийг бакалавр зэрэгтэй төгссөн.

1984 оны 7-р сараас Баян-Өлгий аймгийн АДХГЗ-ны Статистикийн хэлтэст операторчнаар анхны ажлын гараагаа эхэлж, Статистикийн байгууллагад 30 дахь жилдээ ажиллаж байна.1989 онд аймгийн төлөвлөгөө эдийн засгийн хэлтэсийн статистикийн албанд салбар хариуцсан статистикчээр ажиллаж,хариуцсан салбарын мэдээ тайланг цаг хугацаанд үнэн зөв гаргаж улсад мэдээлэх,тухайн салбарт анхан шатны бүртгэл нэвтрүүлэх,мэдээ тайлангийн ирцийг бүртгэх хяналтын карт,самбар нээж ажиллах талаар шинэ санаачилгаа гарган ажилдаа мөрдөж амжилтанд хүрч байсан.1995 онд санхүү эдийн засгийн хэлтсийн статистикийн албанд хүн ам, аж үйлдвэрийн салбар хариуцсан мэргэжилтэнээр ажиллаж хариуцсан салбарын мэдээ тайланг графикт хугацаанд үнэн зөв гаргаж алдаа,тасалдал, хожимдолгүй 100 хувь мэдээлж,өөрийн ажилдаа статистикийн тэргүүний ажилтануудын арга туршлагауудыг байнга нэвтрүүлэн ажиллаж ирсэн. 1997 оноос одоо хүртэл аймгийн статистикийн хэлтэст салбар хариуцсан статистикчаар ажиллаж байна.Хариуцсан бизнесийн регистр, эрүүл мэнд, боловсролын салбарын албан ёсны статистикийн мэдээ тайлангуудын үнэн зөвд тогтмол хяналт тавьж,хугацаанд мэдээлэх ,аж ахуйн нэгж байгууллагын тооцоо судалгаанд хамралтын хүрээг нэмэгдүүлэх ажилдаа анхаарлаа хандуулан ажилласанаар тухайн салбарт мэдээ тайлангийн алдаа хожимдолгүй, бүрэн хамралттай ажиллаж байна.

Графикт албан ёсны мэдээ тайлангуудыг бэлтгэх,төвд дамжуулах, заавар, зөвлөмжүүдийн дагуу ажиллах талаар удирдлагын даалгаврыг мөрдөж ажиллахын хамт,хэлтсээс гарч байгаа төрөл бүрийн статистикийн мэдээлэлээр хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн төрөл бүрийн статистик тоо мэдээллээр хангах ажлыг гардан гүйцэтгэхийн хамт, баримт бүртгэлийг шаардлагын хэмжээнд хөтлөн ажиллаж байгаа мэргэжилтэн юм.Статистикийн тайлан мэдээг орчин үеийн мэдээллийн шинэ техник, технологийг шаардлагын түвшинд эзэмшиж, ҮСХорооноос ирүүлсэн программыг хэрэгжүүлэх, нэвтрүүлэх чадварлаг эзэмших талаар идэвх зүтгэл гарган ажилласан.

ны үр дүнд программаас элдэв алдаа гаргах мэдээ, тайлангийн буруу зөрүү нэвтрэх явдал арилгахын зэрэгцээ сүүлийн үеийн Access програмуудыг ажиллуулах талаар бие дайчлан ажиллаж статистикийн мэдээ,мэдээллийн үнэн бодит байдлыг ханган ажиллахад өөрийн хувь нэмэрийг оруулж байна.Азийн Хөгжлийн банк,Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын санхүү,техникийн дэмжлэгтэйгээр явагдсан ажиллах хүчний түүвэр судалгааны ажилд судлаач-тоологчоор ажилласан,Малын индексжүүлсэн даатгал төслийн шугамаар хийгдсэн хагас жилийн мал тооллогын ажилд 2012

оноос тасралтгүй оролцож, тооллого судалгааг аргачлалын дагуу хийж гүйцэтгэхэд өөрийн оюун ухаан мэдлэгээ дайчлан ажилласан. Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоонд албан бус секторын судалгааг төрөл бүрийн салбарын 15-20 цэгээс санал асуулгын хуудасаар цуглуулан нийт дүндээ тархааж тооцоонд оруулах,дотоодын нийт бүтээгдэхүүний аймгийн нэгтгэл гаргах ажилуудыг амжилттай гүйцэтгэж байна.Өрхийн орлого зарлагын судалгаанд хамрагдсан 94-104 өрхийн сар бүрийн судалгааны материалыг шалгах,компьютерд шивэж оруулах,графикт хугацаанд төвд дамжуулах ажлыг гардан гүйцэтгэж,хэлтсээс гаргадаг статистикийн сар,улирал,жилийн мэдээ тайлангийн дамжуулалтыг бүрэн гүйцэтгэж ,чанарын ахиц гаргахыг урьдтал болгон ажиллаж байгаа мэргэжилтэн юм. Түүнчлэн сум байгууллагуудыг мэдээлэлийн сүлжээтэй холбохтой уялдуулан компьютер эзэмшихэд анхан шатны мэдээлэл олгох, зөвлөмж өгөх, дагалдуулан сургах талаар байнга анхаарч ажилласны үр дүнд 3 байгууллага, 3 сумын бичээч, нягтлан бодогчийг дагалдуулан сургасан юм.

Ш.Манзелханы ажлын амжилтыг үнэлж 2001 онд Үндэсний Статистикийн газрын Хүндэт жуух бичиг, Статистикийн албаны 75 жилийн ойгоор аймгийн Засаг даргын Хүндэт Жуух бичгээр, Монгол Улсад Статистикийн алба үүсч хөгжсөний 80 жилийн ойгоор “Хөдөлмөрийн хүндэт” медалиар тус тус шагнуулж байсан.

Ш.Манзелханы ажилладаг Статистикийн хэлтэс нь ажлын ололт амжилтаар системийн байгууллагуудын дотроос 2009 онд ажлаар хоёрдугаар байр, 2010 онд гуравдугаар байр, 2011 онд зургаадугаар байр, 2012 оны ажлаар тэргүүн байр, 2013 онд ажлын үр дүнгээр гуравдугаар байр эзэлж “Өргөмжлөл” мөнгөн шагналаар шагнагдахад өөрийн хувь нэмэрийг бодитой оруулсан болно.

Ш.Манзелханы статистикийн салбарт он удаан жил үр бүтээлтэй тогтвор суурьшилтай, санаачлагатай ажиллаж буй хөдөлмөр зүтгэлийг Үндэсний статистикийн хорооноос зохих ёсоор үнэлж, дүгнэн 2012 онд ОХУ-ын Иркутск мужийн статистикийн байгууллагын тэргүүн туршлагыг судлах аялал сургалтанд оролцож ирсэн.Монгол улсад Статистикийн алба үүсч хөгжсөний 90 жилийн ойгоор энэ салбарт 30 гаруй жил тогтвор суурьшилтай тасралтгүй үр бүтээлтэй ажилласаныг үнэлж төрийн дээд шагнал “Алтангадас” одонгоор шагнагдав.